



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 01

Улаанбаатар

### НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЖ, ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 80 дугаар зүйлийн 80.4 дэх заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.16 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2021 оны цэвэр ашгаас тус компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 108 төгрөгөөр тогтоож, 2021 оны цэвэр ашгаас 128,518,164 төгрөг хуваарилж, хүн амын орлогын албан татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу суутгасан дүнгээр 2022 оны 5 дугаар сарын 01-ний дотор мөнгөн хэлбэрээр олгосугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй тус компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг хуваарилж, тарааж олгох шийдвэрийн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хуваарилсан ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ХХ) компанитай гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар тарааж олгохыг Гүйцэтгэх захирал (Л.Энхнасан), ерөнхий нягтлан бодогч (Б.Сольрагчаа)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ